



Уул уурхай,
хүнд үйлдвэрийн яам



Монголын ОУИТБС



Сүхбаатар аймгийн ЗДТГ

ЗӨВЛӨМЖ

ЗҮҮН БҮСИЙН АЙМГУУДЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧУУЛГАН

Оролцогчид

- УИХ-ын гишүүн Ж.Батсуурь,
- УУХҮЯ
- БОАЖЯ
- ЗТХЯ
- АМГТГ
- АТГ
- ГЕГ
- Дорнод дахь гаалийн газар
- Бичигт дэх гаалийн газар
- Сүхбаатар аймгийн ИТХ,
- Дорнод аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөл
- Хэнтий аймгийн ОУИТБС-ын Дэд зөвлөл
- “Цайрт минерал” ХХК
- “Монголросцветмет” ТӨҮГ
- “Бэрх-Уул” ХХК
- МУУУА
- ТАН эвсэл
- МБОИЗ
- Дорнод аймгийн Матад, Чойбалсан сумын ЗДТГ, Баяндун сумын ХОБОМ-ийн баг
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан сумын ЗДТГ
- Хэнтий аймгийн Бор-Өндөр, Норовлин, Батноров сумын ЗДТГ
- ОУИТБС-ын Ажлын алба



Засгийн газар, бүх аймаг сумдад хандаж “Олборлох үйлдвэрлэлийн лиценз нь ил, эзэн нь тодорхой, гэрээ нь нээлттэй, шийдвэр нь оролцоотой, иргэд нь мэдэлтэй байх” зорилтуудыг хэрэгжүүлэхийг уриалсан Зүүн бүсийн аймгуудын олборлох салбарын ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 27-28-нд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын оролцогч талууд хамтран зохион байгууллаа.

Чуулга уулзалтад УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, УУХҮЯ, БОАЖЯ, ЗТХЯ, АМГТГ, АТГ, ГЕГ, ТАН эвсэл, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, ОУИТБС-ын Ажлын алба, Сүхбаатар аймгийн ИТХ, ЗДТГ, “Цайрт минерал” ХХК, “Монголросцветмет” ТӨҮГ, “Бэрх-Уул” болон ХХК, Хэнтийн аймгийн ОУИТБС-ын Дэд зөвлөл, Дорнод аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөл, Дорнод дахь гаалийн газар, Бичигт дэх гаалийн газар, зүүн бүсийн аймгуудын сумдын удирдлагууд, олон талт зөвлөлийн төлөөллүүд 100 гаруй хүн оролцлоо.

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах зөвлөмжүүдийг гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгч

- Газрын тос болон уран, газрын ховор элемент зэрэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохоос нь өмнө УАБЗ-өөр хэлэлцүүлдэг байсныг буцааж сэргээх.

Улсын Их Хуралд

- Стратегийн ордуудын хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд өндөр түвшний мэргэжлийн багийн хөндлөнгийн хяналтыг оруулж, саналыг тусгадаг болгох;
- Эрдэс баялгийн салбарын хуулиудад олон нийтээр хэлэлцүүлээгүй, нууцаар оруулсан заалтуудыг анхааралдаа авч, хуульд нийцүүлэх;
- Өмнө нь урт нэртэй хуулиар зохицуулж байсан гол мөрөн, ойн сан бүхий газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох заалтыг Ашигт малтмалын тухай шинэчилсэн найруулгад тусгах.

Зүүн бүсийн аймгуудаас сонгогдсон УИХ-ын гишүүд

- УИХ-аар хэлэлцэх гэж байгаа олборлох салбарын хуулийн өөрчлөлтүүдэд зүүн бүсийн чуулганы санал зөвлөмжүүдийг тусгахад анхаарч ажиллах;
- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад холбогдох хууль тогтоомжийн төсөлд орон нутгийн удирдлагын оролцоог нэмэгдүүлэх.

Засгийн газарт

- Эрдэс баялгийн эрх зүйн орчны шинэчлэлд олон нийтийн оролцоог хангаж, УИХ-д өргөн барих гэж буй хуулийн төслүүдийг ил болгох;
- Газрын тос, уран, газрын ховор элементийн тусгай зөвшөөрөл олголтыг УАБЗ-өөр хэлэлцэн шийдвэрлэдэг байхаар хуульчлах;
- Зүүн бүсийн уурхайнуудын эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг

- яаралтай барьж байгуулан, экспорт, ложистикийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, вагоны хүрэлцээг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын тогтоолоор зохицуулж буй Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний нөхцөлд орон нутгийн бүх шатны удирдлагын оролцоо болон гэрээний үнийн дүнгийн аргачлалыг нарийн тодорхой зааж, хуульчлах;
- Орон нутгийн чанартай уурхайг дэмжих, орон нутагт татварын орлогоос үлдэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарч, холбогдох хууль эрх зүйн зохицуулалтуудыг хийх;
- Хайгуулын тусгай зөвшөөрөл олголт, боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд олон нийтийн оролцоог хангаж, төслийн нөлөөллийг ил тод хэлэлцүүлэх;
- Боомтыг бүтээн байгуулалт нь тухайн газар нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг идэвхижиж, түүхий эдийн тээвэрлэлт эрчимжихэд чухал нөлөө үзүүлэх тул түүнээс үүдэн гарах экологийн доройтлоос сэргийлэх;
- Монгол Улсын нийт газар нутгийн экосистемийн даацад тохирсон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тооцоо судалгааг гаргах;
- Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах, уул уурхайн тусгай зориулалтын хатуу хучилттай авто зам баригдах хүртэлх хугацаанд орон нутагт уул уурхайн тээвэрлэлт гүйцэтгэх талаар зохицуулалт, журам гаргах /УУХҮЯ, ЗТХЯ, БОАЖЯ нэгдсэн уялдаатай бодлого барьж хамтран ажиллах/
- Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн босоо тогтолцоотой байгууллагууд орон нутгийн

удирдлагыг мэдээллээр саадгүй хангадаг болох;

- Засгийн газар “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-аар цаг алдалгүй батлуулж, Нээлттэй Засгийн түншлэл, Авилгатай тэмцэх үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- ОУИТБС-н Үндэсний зөвлөлийн гишүүдийг хариуцлагажуулах, хоорондын ажлын уялдааг сайжруулах, Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудад идэвхитэй, эргэх холбоотой оролцуулж байх.

Сангийн яаманд

- Орон нутгийн чанартай уул уурхайн компанийн аймгийн ОНХС-нд төвлөрүүлдэг татвар төлбөрөөс сумын ОНХС-нд төвлөрүүлэхэд анхаарах;
- АМНАТ-ийг зориулалтын бусаар зарцуулж ирсэнийг зогсоох, ирээдүй хойчдоо өвлүүлэх эрх зүйн орчныг хуульчлах;
- Байгалийн баялгаас улсын төсөвт төвлөрч байгаа хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн менежментээр удирдах эрх зүйн орчныг бий болгох.

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд

- Уул уурхайгаас болж доройтсон газрын нөхөн сэргээлтийн стандартыг боловсруулах, сайжруулах, мөн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг ил тод болгох;
- БОННУ-ний тайланг шуурхай баталдаг болох, таван жил тутамд үнэлдэг хугацааг ойртуулах;

- Хариуцлагатай уул уурхайн хяналт, үнэлгээг хэрэгжүүлэхэд МУУҮА, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллах;
- Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хариуцлагыг өндөржүүлэх;
- Хүчин төгөлдөр лицензүүд хуулийн дагуу олгогдсон эсэхэд хараат бус хөндлөнгийн хяналт, мониторинг хийлгэхэд УУХҮЯ-тай хамтран ажиллах;
- Нөхөн сэргээлтийн ажлыг 21 аймагт хүртээмжтэй, чанартай хийж гүйцэтгэх;
- Угаар ихтэй нүүрсний уурхайнуудад тавих хяналтыг сайжруулах;
- БОНБУ, БОМТ-нд тусгагдсан үнийн дүнг орон нутгт төвлөрүүлж, нөхөн сэргээлтийн сан үүсгэх;
- БОНБУ-нд иргэд, орон нутгийн оролцоог бий болгож, Ажлын хэсэг байгуулж батлагдсан нийт үнэлгээнд үнэлэлт дүгнэлт өгөхөд ТАН эвсэлийн оролцоог хангах;
- УИХ-д өргөн барихаар төлөвлөж байгаа болон өргөн барьсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Үндэсний баялгийн сангийн тухай, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг ил болгох, олон нийтэд сурталчлах, санал авах ажлыг зохион байгуулах;
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахад орон нутгийн оролцоог хангахад анхаарч ажиллах;
- Ашигт малтмалын тухай хуульд уурхай эхлэхээс хаах хүртэлх үе шатанд иргэд, орон нутгийн оролцоог хангах;
- Өмнө нь Урт нэртэй хуулиар зохицуулж байсан гол мөрөн, ойн сан бүхий газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох заалтыг Ашигт малтмалын тухай шинэчилсэн найруулгад тусгах;
- Хил гаалийн хүндрэлийн улмаас уурхайнуудын технологийн материалын нийлүүлэлтийн саатлыг яаралтай шийдвэрлэхэд Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран ажиллах;
- УИХ-д өргөн барьсан хуулийн төслүүдээ олон нийтээр хэлэлцүүлсэн хувилбараар батлуулахад анхаарах;
- Бичигтийн боомт руу тээвэрлэлт хийдэг компаниуд зөвшөөрлийн дагуу хатуу хучилттай авто зам барих ажлыг эрчимжүүлэх, авто зам барьж дуусах хүртэл шороон замаар түр тээвэрлэлт гүйцэтгэх талаар УУХҮЯ, БОАЖЯ хамтран шийдвэр гаргах;
- “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Сүхбаатар болон Дорнод аймгийн нутагт барих 140 гаруй км авто замыг яаралтай бариулахад

Хууль зүй , дотоод хэргийн яаманд

- Иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуурыг бий болгох, журамлах, ТББ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар ТББ-уудын хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг тусгах;
- ОУИТБС-ын ажлыг дэмжиж ажиллах.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд

- ҮХНӨ-ийн дагуу нийтийн өмчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад ард олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг хийх;

УУХҮЯ-тай хамтран ажиллах;

- Уул уурхайн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж гаргаж үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад хүргүүлэх.

Ашигт малтмал, газрын тосны газарт

- Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх;
- Хуулийн дагуу олгосон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад орон нутгийн удирдлагатай ойр хамтран ажиллах;
- Тусгай хэрэгцээнд бүртгэн авсан газрын тухай суманд явуулсан албан бичгийн хуулбарыг аймгийн ЗДТГ-т хүргүүлж байх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг төсөл хэрэгжүүлж эхлэхдээ орон нутгийн иргэдтэй ойлголцоход чиглэсэн хууль эрх зүйн болон бусад мэдлэг мэдээллээр хангах нэгдсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Лицензүүдийн ашиглалтад эргэж хяналт тавьж, 1-2 жил ажиллаад үйл ажиллагаагаа зогсоож, газар хөндөж орхидог хуулийн этгээдүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, олгосон тусгай зөвшөөрлийг бүрэн гүйцэт ашиглахад анхаарах;
- Туслан гүйцэтгэгч ажиллуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хатуу хяналт тавих;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Уулын ажлын төлөвлөгөөг батлахдаа ОНХАГ-ний хэрэгжилт, биелэлтийг заавал тооцох;

- Шинээр олгогдож байгаа хайгуулын талбай нь Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газартай давхцаж байгаа тул тайлбар мэдээллийг орон нутагт өгч, эргэх холбоотой хамтран ажиллах;
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Төмстэйн сэрвэн газрыг хайгуулын сонгон шалгаруулалтын талбайд оруулах;
- Ашиглалтын үйл ажиллагаа явуулах холбогдох бичиг баримт, Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замын чиглэл, БОМТ батлагдсаны дараа уулын ажлын төлөвлөгөө батлахыг зохицуулах;
- Хайгуулын тусгай зөвшөөрлийг олон нийтийн оролцоо, орон нутгийн оролцоогүйгээр олгохгүй байх;
- Өмнө нь олгогдсон хайгуулын 900, ашиглалтын 1700 тусгай зөвшөөрөлд хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгааг ТББ-ийн оролцоотой шалгах ажлын хэсэг байгуулж үнэлэлт дүгнэлт өгөх;
- Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгохдоо орон нутаг, иргэдийн саналыг заавал авсан байхыг хуульчлах.

Орон нутгийн удирдлагууд

- Байгаль орчин, ус бага ашигладаг технологи бүхий ААН-үүдийг дэмжих, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд санаачилгатай ажиллах;
- Уул уурхай дагасан орон нутгийн ЖДҮ-ийг бодлогоор дэмжих;
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг iltodgeree.mn - д хугацаа алдалгүй, тогтмол оруулж хэвших, ингэхдээ сонсох ажиллагаа хийгдсэн гэрээг оруулдаг болох;

- Компаниудтай байгуулж буй гэрээний нөхцлийг ил тод байлгах, ялангуяа энэ нь захиргааны гэрээ болохын хувьд эрх ашиг нь хөндөгдөх иргэдийг оролцуулсан сонсох ажиллагаа явуулж саналыг нь тусгахад онцгой анхаарах;
- Дэд зөвлөлийн даргыг томилохдоо урт хугацаанд тогтвортой ажиллуулахад анхаарах;
- ОУИТБС-ыг Захиргааны хуульд нийцүүлэн батлах, гаргасан тайланг ашиглах, хэрэглэх ур чадварт суралцах. Нутгийн иргэд, олон нийтэд сурталчлах танилцуулах ажлыг зохион байгуулах;
- Орон нутагт газрын тосны олборлолт өргөжих төлөвтэй байгааг харгалзан Дорнод аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж ирсэн “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа, орон нутагтай харьцаж ирсэн практик, сургамжийг нэгтгэн дүгнэж дараагийн орон нутаг, иргэд малчдад танилцуулах олон нийтийн оролцоо зөрчил маргааныг шийдвэрлэх механизмыг бий болгох.

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд

- Тусгай зөвшөөрөл олголт нь аймаг, сумын газар нутгийн 10 хувиас хэтрэхгүй байх ҮАБЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх олон талт Ажлын хэсэг байгуулан ажил хэрэг болгох;
- ОУИТБС-н тайланд мэдээлэл өгөхгүй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн асуудлыг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, сануулга өгөх ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулах агуулга, хэлбэр стандартыг (борлуулалтын орлого, батлагдсан нөөц)

- бий болгох, орон нутгийн онцлогийг шингээсэн зохицуулалтыг хавсралтад тусгаж байхыг Үндэсний зөвлөлийн хурлаар шийдвэрлэж шийдвэр гаргах;
- Хариуцлагагүй уул уурхайн шалгуурыг гаргаж хариуцлага тооцдог механизм, хариуцлагатай ААНБ-д урамшуулдаг хөшүүрэгтэй болох санал боловсруулах.

Зүүн бүсийн аймгуудын ОУИТБС-ын Дэд зөвлөлүүдэд

- АМГТГ-ын үйл ажиллагааны хүрээнд зүүн бүсэд бэлтгэгдсэн сургагч багш нартай хамтран ажиллаж, иргэдийг мэдлэг мэдээллээр хангах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг төсөл хэрэгжүүлж эхлэхдээ орон нутгийн иргэдтэй ойлголцоход чиглэсэн хууль эрх зүйн болон бусад мэдлэг мэдээллээр хангах ажилд АМГТГ болон Монголын ОУИТБС, ТАН эвсэл, мэргэшсэн ТББ, МУУҮА-тай хамтран ажиллах.

Экологийн цагдаагийн албанд

- Хууль бусаар ашигт малтмал олборлогч этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсоож, үр дүнтэй тэмцэх;
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Төмстэйн сэрвэн нэртэй газрыг хууль бус ашигт малтмал олборлогчдоос хамгаалахад цагдаагийн байгууллагад санхүүжилт олгох.

Компаниуд

- Худалдан авалтын бодлогоороо аль болох орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих;

- Уурхайн эдийн засгийн үнэлгээнээс гадна байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийж үнэлдэг болох;
- Орон нутгийн хөгжлийн бодлогод төслийн бизнесийн бодлогыг уялдуудан дэмжих замаар нийгмийн дэмжлэг олж авах, хамтын үнэ цэнийг бий болгох;
- ОУИТБС-ийн үйл ажиллагаанд идэвхитэй хариуцлагатай оролцох;
- Орон нутаг, иргэдэд үнэн бодит мэдээллийг тухай бүр гаргаж өгч байх.

Зохион байгуулагчид

- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг бүсийн чуулганы үеэр ярилцах;
- Хурлын хэлэлцүүлгийг иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн, асуулт хариултад төвлөрсөн байдлаар явуулж, панелистууд дахин ярьж, цаг авдаг байдлыг багасгаж, шууд асуулт хариулах хэлбэрээр явуулах нь үр дүнтэй.

Чуулга, уулзалтын оролцогчид
2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр
Сүхбаатар аймгийн Баруун-Урт хот

